



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 105

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 31,532.964.00 (гучин нэгэн сая таван зуун гучин хоёр мянга есөн зуун жаран дөрвөн) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

2.1. БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжсэн станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгах, ашиглалтын хугацааны элэгдэл тооцох, зээлийн гэрээ байгуулах асуудлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах;

2.2. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал болон тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах.

3. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчим хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Б.Бат-Эрдэнэ)-д Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 4.2 дахь заалтыг ханган ажиллаж, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

3.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

3.2. Стандарт хэмжил зүйн газраас Монгол Улсад ашиглахыг зөвшөөрсөн загварын халуун, хүйтэн усны тоолуур суурилуулах, засварлах тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхлэх;

3.3. Төрийн өмчийн эд хөрөнгийг бусад хуулийн этгээдэд ашиглуулахдаа эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан журмыг баримтлан ажиллах, 2022 онд Төрийн өмчийг эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүй бусдад ашиглуулснаас олсон орлого 25,432,964.00 (хорин таван сая дөрвөн зуун гучин хоёр мянга есөн зуун жаран дөрвөн) төгрөгийг Улсын төсвийн 100900000703 дансанд 2024 оны 4 дүгээр сард багтаан төвлөрүүлэх, цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх;

3.4.“Хеви индастрис техноложи групп” ХХК болон “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанид буцаан авах нөхцөлтэйгээр шилжүүлж дутагдсан 3 (гурав) нэр төрлийн бараа материалыг буцааж авах;

3.5.Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөл агуулахад үлдэгдэлтэй, зарцуулалтгүй, ашиглалтгүй, насжилт өндөртэй, бага өртөгтэй бараа материалын талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах;

3.6.Компанийн 2496 м2, 4 ширхэг эзэмших/ашиглах эрхийн газрыг Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу үнэлж үнэлгээний дүнг мэргэжлийн үнэлгээний байгууллагаар хянан баталгаажуулах, санхүүгийн тайланд тусгах;


3.7.Төслийн хүрээнд үнэ төлбөргүй бий болсон сэндвичэн барилга, зарим дагалдах хөрөнгийн үнэлгээг тогтоох, төрийн өмчид бүртгэж авах талаар санал боловсруулан Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх;

3.8.Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу үндсэн хөрөнгө бэлтгэх, төлөвлөгөөний хөдлөл өөрчлөлтийг хууль тогтоомжид заасны дагуу Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

3.9.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн дагуу дотоодын тооллогыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.10.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА		Б.ЦЭНГЭЛ
ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА		Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 3 дугаар сарын 8-ний өдрийн 105 дугаар тогтоолын хавсралт



“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанид хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн /төгрөг/	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Бараа материал дутагдуулсан, тооллогын дүнгээрх дутагдлын зөрүүг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй	6,100,000.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.3, 73 дугаар зүйлийн 73.2 дугаар заалт
2	Компаний 2946 м.кв талбай бүхий газар эзэмших эрхийг үнэлж, бүртгээгүй	-	Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол
3	Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг зөвшөөрөлгүй түрээслүүлсэн.	25,432,964.00	Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах.
<b>Нийт дүн</b>		<b>31,532,964.00</b>	<b>(Гучин нэгэн сая таван зуун гучин хоёр мянга есөн зуун жаран дөрвөн) төгрөг</b>